

PRFDI ТӨСЛИЙН МЭДЭЭ

(ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ)

Дугаар № 4-2013 оны 1 сар

Агуулга

- ГХОГ-ын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт
- Шинээр томилогдсон төслийн удирдагчийн мэндчилгээ
- Төслийн шинэ менежер болон зохицуулагчийн танилцуулга
- Өгөгдлийн санг хөгжүүлэх ажлын явц ба мэдээ
- PRFDI төсөл удахгүй хэрэгжиж дуусна
- НЦҮ-ний бэлтгэл ажил
- Мэргэжилтнүүдийн семинар, судалгааны ажил

Энэ дугаарт

Төслийн хамгийн сүүлчийн хэсэг буюу 3 дахь жилийн ажил 2012 оны 3-р сараас эхэлсэн. Төслийн дуусах шатны энэ хугацаанд хэд хэдэн чухал ажлууд хийгдсэн байна. ГХОГ нь засгийн газрын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд дахин шинэчлэгдэн Эдийн засгийн хөгжлийн яамны нэг хэлтэс болон зохион байгуулагдсан бөгөөд энэ өөрчлөлтийн хүрээнд манай төслийн удирдагч, менежер, зохицуулагч гэх мэт олон ажилтан өөрчлөгдөн шинэ хүмүүс томилогдсон. Энэ дугаарт энэ өөрчлөлт болон Монгол дахь ГШХО –ын талаар төслийн удирдагчийн танилцуулга орсон болно. Мөн өгөгдлийн санг хөгжүүлэх болон НЦҮ –ний бэлтгэл ажлын явц, богино хугацааны мэргэжилтнүүдийн семинар болон судалгааны ажлуудын талаар орсон болно.

ГХОГ-ын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт

2012 оны 6 сард болсон Улсын Их хурлын сонгуулийн дараа Засгийн газрын бүтэц өөрчлөгдөн зарим агентлагууд татан буугдаж шинэ яамд байгуулагдсан. Хуучин ГХОГ нь татан буугдаж шинэ байгуулагдсан Эдийн засгийн хөгжлийн яамны Гадаадын Хөрөнгө Оруулалтын Зохицуулалт Бүртгэлийн Газар (ГХОЗБГ) болсон. Шинээр байгуулагдсан Эдийн засгийн хөгжлийн яам нь хуучин Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо (ҮХШХ), Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засаг хамтын ажиллагааны хэлтэс, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хамтын ажиллагааны хэлтэс болон ГХОГ-ыг нэгтгэн байгуулагдсан. Эдийн засгийн хөгжлийн яам нь 6 хэлтэстэй. Үүнд: (1) Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлтийн газар, (2) Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, тусламжийн бодлогын газар (ЭЗХАЗТБГ), (3) Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар (хуучин ГХОГ), (4) Инноваци, төр-хувийн хэвшлийн түншлэлийн газар (ИТХХТГ), (5) Төрийн

захиргааны удирдлагын газар, (6) Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар.

Дээрх өөрчлөлттэй уялдан төслийн Хамтарсан зөвлөлдөх хороонд багтаж байсан зарим агентлаг хэлтсүүд Эдийн засгийн хөгжлийн яаманд нэгдсэн. Тиймээс ГХОЗБГ, PRFDI төсөл болон JICA хамтран хэлэлцэж төслийн Хамтарсан зөвлөлдөх хорооны гишүүдэд Эдийн засгийн хөгжлийн яамны ГХОЗБГ, ЭЗХАЗТБГ, ИТХХТГ, МҮХАҮТ болон Монголын бизнесийн зөвлөлийг оруулахаар болсон. Хамтарсан зөвлөлдөх хороо болон ажлын хэсгийн гишүүдийг 2012 оны 12 сарын 5 –ны өдрийн хурлаар шинээр томилсон. Төслийн удирдагч С.Жавхланбаатар нь 2012 оны 9 сард Эдийн засгийн хөгжлийн яамны ГХОЗБГ-ын даргаар томилогдон ажиллахаас өмнө Гадаад харилцааны яаманд ажиллаж байсан юм. (ХЗХ болон Ажлын Хэсгийн гишүүдийг 3-р хуудаснаас харна уу).

Төслийн шинэ удирдагчийн мэндчилгээ

Эрхэм уншигчид аа,

Та Эдийн засгийн хөгжлийн яамны ГХОЗБГ болон Японы JICA ОУБ –ийн хамтран хэрэгжүүлж байгаа PRFDI төслөөс гаргадаг ээлжит мэдээллийн товхимолтой танилцана уу. Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал үүрэг гүйцэтгэж байна. Монгол Улс гадаадын хөрөнгө оруулалтад зах зээлээ нээсэн цагаас өнөөг хүртэл 10 мянга гаруй гадаадын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгж байгуулагдаж, 10 гаруй тэрбум ам.долларын цэвэр хөрөнгө оруулалт хийгдээд байна. Та бүхэнд ГХОЗБГ-ын үүрэг болон Монгол дахь ГШХО –ын өнөөгийн байдлын талаар товч танилцуулья. (үргэлжлэл 3-р хуудсанд)



Төслийн шинэ менежер болон зохицуулагч

ГХОЗБГ-ын ахлах мэргэжилтэн Д. Цэцэгмаа төслийн менежерээр томилогдон ажиллаж байна. Хэдийгээр Д. Цэцэгмаа нь энэ төслийн хувьд шинэ боловч ГХОЗБГ-т (хуучин ГХОГ) долоон жил гаруй ажиллаж байгаа ГШХО-ын талаар багагүй туршлагатай мэргэжилтэн. Мөн ГХОЗБГ-т (хуучин ГХОГ) 2011 оны 11 сараас ажиллаж байгаа мэргэжилтэн Д.Танан төслийн зохицуулагчаар томилогдон ажиллаж байна. Тэд төслийн багт багтаж хамтран ажиллах болсондоо таатай байгаагаа илэрхийлсэн бөгөөд төслийн багийн зүгээс шинэ менежер болон зохицуулагчдаа талархал илэрхийлж цаашдын хамтын ажиллагаанд амжилт хүсье.



PRFDI/ГХОЗБГ, ЭЗХ Яам
Төслийн байршил
Самбуугийн гудамж, Засгийн Газрын байр-11, 809
Улаанбаатар -211238, Монгол Улс
Утас : +976 (11) 318-467 Факс: +976 (11) 324-076
www.prfdi.mn



ЖАЙКА Байгууллагын Монгол дахь Төлөөлөгчийн газар
Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар
Төв шуудан 682, Улаанбаатар 211213, Монгол Улс
Утас: +976 (11) 312-393, +976 (11) 311-329
Факс: +976 (11) 310-845 www.jica.go.jp

Өгөгдлийн санг хөгжүүлэх ажлын мэдээ

PRFDI төслийн хүрээнд хийгдэх гол ажлуудын нэг нь ГХОЗБГ-ын (хуучин ГХОГ) хэрэглээний програм хангамж (ХПХ), өгөгдлийн санг хөгжүүлэх ажил юм. Энэ ажлын үндсэн 2 бүрэлдэхүүн хэсэг нь ГХО-ын бүртгэлийн санг сайжруулах болон ГХОЗБГ болон бусад холбогдох төрийн байгууллагуудаас статистик мэдээллүүдийг авч өгөгдлийн санд оруулах юм.

PRFDI төсөл нь 2011 оны 12 сараас ГХО-ын бүртгэлийн санг сайжруулах ажлыг гүйцэтгэхээр INI Co., Ltd гэдэг дотоодын компанитай хамтран ажилласан. ГХОЗБГ болон JICA Төслийн багтай хамтран INI компанийн програм хангамжийн инженерүүд ГХОЗБГ-ын дотоод сүлжээнд web-based application нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэсэн. Өгөгдлийн санг хөгжүүлэх



Зураг 2: ГХОЗБГ-ын бүртгэлийн ажилтнууд шинэ өгөгдлийн санг хэрэглэж байна

цаашид бусад агентлагуудтай гэрээ байгуулах ажлууд яригдаж байна. Эхний ээлжинд ТЕГ, НДЕГ, ГЕГ, УБЕГ, ХХҮГ болон Монгол Банк зэрэг газруудтай хамтран ажиллах юм.

Эдгээрээс бусад агентлагуудтай гэрээ байгуулах боломжийн талаар судлахаас гадна ГХОЗБГ нь State VPN (a secure private network) буюу төрийн нэгдсэн сүлжээнд холбогдон өгөгдөл солилцох асуудлын талаар судалж байна. Ингэснээр мэдээллийг илүү найдвартай бөгөөд хурдан дамжуулах боломжтой.


Дээр дурдсанчлан статистикийг ГХОЗБГ-ын бүртгэлийн мэдээлэл болон бусад агентлагуудаас авсан мэдээлэлд тулгуурлан гаргах юм. ГХОЗБГ-ын тодорхойлсноор дээрх статистикийг зорилго болон хэрэглээгээр нь 4 хэсэг болгох юм. Үүнд: 1) ГХОЗБГ удирдлага, хяналт шинжилгээ; 2) Агентлаг хоорондын хамтын ажиллагаа; 3) ГШХО статистик; 4) ХО Дэмжих үйлчилгээ.

Ялангуяа ГШХО-ын статистик нь ГХОЗБГ-ын хувьд нилээн чухал ач холбогдолтой. ГШХО-ын статистик нь доорх мэдээллийг агуулна. Үүнд: тайлан тэнцэл (ТТ) болон шууд хөрөнгө оруулалтын позиц; санхүүгийн болон үйл ажиллагааны

мэдээлэл; үүсгэн байгуулсан болон эзэмшлийн мэдээ; болон Монголын талаарх лавлах мэдээлэл. Эдгээр ангилалуудыг US Bureau of Economic Analysis (BEA) -ын ангилалаас авч ГХОЗБГ болон JICA Төслийн баг Монголын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

Өгөгдлийн санг хөгжүүлэх болон програм хангамжыг сайжруулах ажил нь 2012 оны 9 сард дууссан бөгөөд үүний дараа ГХОЗБГ-ын бүртгэлийн ажилтнуудад сургалт явуулсан.

Ингээд 2012 оны 10 сараас ГХОЗБГ-ын бүртгэлийн зарим ажилтнууд шинэ өгөгдлийн санг хэрэглэж эхэлсэн. 2013 оноос нийт ажилтан шинэ өгөгдлийн санг хэрэглэж эхэлнэ.



Зураг 1: INI компаниас бүртгэлийн ажилтнуудад сургалт явуулж байна.

ажлыг 2012 оны 9 сард хүлээлгэж өгсөн.

Өгөгдлийн санг хөгжүүлэх ажлын 2 дахь хэсэг 2012 оны 3 сараас эхэлсэн. Энэ ажил үндсэн 2 хэсэгтэй. Үүнд: (1) Монгол дахь бусад холбогдох төрийн байгууллагууд болон агентлагуудтай холбоотой ажиллах мэдээлэл солилцох (2) статистик мэдээллүүдийг үүсгэх.

Статистик мэдээлэл, өгөгдөл солилцох ажлыг гүйцэтгэх хүрээнд хэд хэдэн агентлаг газруудтай гэрээ байгуулсан ба



Зураг 3: ГХОЗБГ-ын шинэ сервер.

Хакан Юксел, PRFDI төслийн мэргэжилтэн, Мэдээллийн менежмент (1)

Төсөл удахгүй хэрэгжиж дуусна

Шинэ 2013 оны мэнд хүргэе.

PRFDI Төсөл нь 2010 оны 11 сард эхэлсэн бөгөөд түүнээс хойш ГХОГ, ГХЯ, ҮХШХ, СЯ, Хөрөнгө Оруулалтын Орчны Сайжруулах Зөвлөлдөх Зөвлөл, МУХАУТ болон Монголын Бизнесийн Зөвлөл гэсэн 7 оролцогч талуудаас бүрдсэн ажлын хэсэгтэй хамтран ажилласан. Төслийн хүрээнд доорх ажлууд амжилттай хэрэгжсэн. Үүнд: Төслийн суурь судалгаа болон орчны судалгаа; ГШХО-ын нөлөөллийн талаарх Япон улсад хийсэн сургалт, Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын талаар Чех болон Польш улсад хийсэн туршлага судлах аялал; богино хугацааны мэргэжилтнүүдийн зохион байгуулсан хэд хэдэн семинар сургалтууд орно. Төслийн 2 дахь жилийн

ажлын хүрээнд 2012 оны 1 сард ГХОЗБГ-ын даргын зөвшөөрөлтэй хөрөнгө оруулалтын үйлчилгээг сайжруулах зорилготой ГХОЗБГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах ажлыг гүйцэтгэсэн. Төслийн 3 дахь жилд ГШХО-ын бүртгэлийн өгөгдлийн санг сайжруулах ажлыг ГХОЗБГ дээр хийж гүйцэтгэсэн бөгөөд ингэснээр ГШХО-ын бүртгэлийн статистик илүү найдвартай, үнэн зөв болно. Улсын Их Хурлын сонгуулийн дараа буюу 2012 оны 8 сард засгийн газраас Эдийн Засгийн Хөгжлийн Яамыг 6 хэлтэстэй шинээр байгуулсан бөгөөд PRFDI төслийн 7 оролцогч талуудын 4 нь энэ шинэ яаманд нэгдсэн. Үүнтэй уялдан төслийн оролцогч талуудын бүтцэд мөн өөрчлөлт гарсан. Энэхүү Засгийн

Газрын бүтцийн өөрчлөлтийн нэг давуу тал нь ГХОГ нь Эдийн Засгийн Хөгжлийн Яаманд нэгдэж ГХОЗБГ болж өөрчлөгдөн Эдийн Засгийн Хөгжлийн Яам нь ГШХО-ын бодлого боловсруулах үүрэгтэй болж байгаа явдал юм. Учир нь ГШХО-ын бодлого болон бодлогын хэрэгжилтийн хоорондын холбоо хамгийн чухал. Хэдийгээр энэхүү өөрчлөлт нь төслийн ажилд бага зэрэг хүндрэл учруулсан боловч цаашид төслийн чадварлаг шинэ бүрэлдэхүүн улам эрч хүчтэй ажиллаж үлдэж байгаа 2 чухал ажил болох НЦҮ-ий үйл ажиллагааны төлөвлөгөө болон ГШХО-ыг дэмжих Road Map боловсруулах ажлуудыг амжилттай гүйцэтгэнэ гэж найдаж байна.

Хироши Мацука, PRFDI Төслийн ахлах зөвлөх,

(Хуудас 1-ийн үргэлжлэл: Төслийн удирдагчийн мэндчилгээ)

ГХОЗБГ нь гадаадын хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, сурталчлах, зохицуулан хянах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон төлөөлөгчийн газрыг бүртгэх зэрэг үндсэн үйл ажиллагааг явуулж байна.

ЭЗХ яамны ГХОЗБГ нь Монгол Улс дахь ГШХО-ыг дэмжих, зохицуулах үүрэг бүхий Засгийн газрын байгууллага юм. Эдийн засгийн хөгжлийн яамны Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар нь дараах үүрэгтэй:

- Монгол Улсын бизнес, ХО-ын орчныг сурталчилах.
- ГШХО– тай холбоотой хууль тогтоомж бодлогыг хэрэгжүүлэх.
- Хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас статистик мэдээллийг нэгтгэх, мэдээлэх
- ГХО-тай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг хянан шийдвэрлэх
- ГШХО-ын бодлого, зохицуулалтыг хянан үзэх
- ГШХО-ын нөхцөл байдлыг судалж, дүн шинжилгээ хийх

Өнөөдөр Монгол Улс хөрөнгө оруулалт хийхэд тааламжтай орны нэгд зүй ёсоор тооцогдож байгаа нь олон улсын судалгааны байгууллагуудын тооцоололтой нийцэж байгаа юм. Тухайлбал, Дэлхийн банкны “Бизнес эрхлэх нь - 2013” судалгаагаар Монгол улс 183 орноос 76 – р байрт жагсаж байна. Энэхүү үзүүлэлтэд гадаадын хөрөнгө оруулагчдыг татахад чухал хүчин зүйл болох шинээр бизнес эхлүүлэх таатай орчин, хөрөнгийг бүртгэлийн хялбар байдал, хөрөнгө оруулагчдыг хамгаалах найдвартай байдал зэрэг үзүүлэлтүүд нөлөөлжээ. Түүнчлэн “Эдийн засгийн Чөлөөт байдлын Индекс 2013”-т Монгол улс өмнөх жилээс 6 оноогоор дээшилж, 184 орноос 75-д орсон. Мөн энэ үзүүлэлтээрээ Ази-Номхон далайн бүсийн 41 орноос өмнөх жилийн үзүүлэлттэй харьцуулахад өөрчлөгдөөгүй 12-т жагсаж байна. 2012 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсад 1990 оноос хойш 112 орны 12118 гадаадын хөрөнгө оруулалттай компани бүртгэгдэж, нийт 11,5 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт хийжээ.

Нийт бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалтыг салбараар авч үзвэл:

Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбарт – 73.9 хувь,

Худалдаа, нийтийн хоолны салбарт – 16.3 хувь,

Банк, санхүүгийн үйл ажиллагаа – 1.49 хувь,

Хөнгөн үйлдвэрийн салбарт – 0.94 хувь,

Инженерийн барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл – 0.89 хувь

Манай улсад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалтыг улс орноор нь авч үзвэл:

БНХАУ - 3.65 тэрбум ам дол. буюу 31.71 %
 Нидерланд - 2.66 тэрбум ам.дол. буюу 23.16 %
 Люксембург – 1.03 тэрбум ам.дол буюу 9.01 %
 Виржиний арлууд (Англи)- 0.86 тэрбум ам.дол буюу 7.48%
 Сингапур - 0.62 тэрбум ам. дол. буюу 5.45 %
 Канад - 0.48 тэрбум ам дол. буюу 4.23 %
 БНСУ - 0.33 тэрбум ам дол. буюу 2.93 %
 АНУ – 0.29 тэрбум ам дол. буюу 2.54%
 БНХАУ /Гонконг/ - 0.2 тэрбум ам дол. 1.8 %
 Япон – 0.18 тэрбум ам дол. буюу 1.6 % тус тус эзэлж байна.

Эрдэс баялгийн асар их нөөц, өргөн уудам газар нутаг, хөдөө аж ахуйн нөөц боломж, газарзүйн онцлог байршил, эдийн засгийн хурдацтай өсөлт зэрэг олон давуу хүчин зүйл хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байна. Нөгөө талаас Монгол дахь хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, тогтвортой болон ил тод байдлыг хангах чиглэлд төр, засгийн зүгээс чухал ач холбогдол өгч байна.

Энэ хүрээнд ГХОЗБГ нь гадаадын хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах, сурталчлах, зохицуулан хянах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж болон төлөөлөгчийн газрыг бүртгэх зэрэг үндсэн үйл ажиллагааг явуулж байна.

Таны бизнесийн үйл ажиллагаанд өндөр амжилт хүсч, сайн сайхныг ерөөе.

ГХОЗБГ-ын дарга
С. Жавхланбаатар

Шинээр томилогдсон Хамтарсан зөвлөлдөх хороо болон ажлын хэсгийн гишүүд

Хамтарсан зөвлөлдөх хорооны гишүүд (Монголын талын)

Хаттарсан зөвлөлдөх хорооны дарга:

С.Жавхланбаатар, Эдийн засгийн хөгжлийн яамны ГХОЗБГ-ын дарга

Гишүүд:

Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засаг хамтын ажиллагаа, зээл тусламжын газрын дарга

Эдийн засгийн хөгжлийн яамны Инноваци, төр-хувийн хэвшлийн газрын дарга

МҮХАҮТ-ийн Гадаад харилцаа хөрөнгө оруулалтыг дэмжих хэлтэс

Монголын бизнесийн зөвлөлийн дэд дарга

Төслийн удирдагч болон төслийн менежерийн удирдлаганд ажиллах ажлын хэсгийн гишүүд

Н.Дашдэмбэрэл, Эдийн засгийн хөгжлийн яамны ГХОЗБГ-ын мэргэжилтэн

Д.Танан, Эдийн засгийн хөгжлийн яамны ГХОЗБГ-ын мэргэжилтэн

Д.Сувдаа, Эдийн засгийн хөгжлийн яамны Эдийн засаг хамтын ажиллагаа, зээл тусламжын газрын мэргэжилтэн

Д. Анударь, Эдийн засгийн хөгжлийн яамны Инноваци, төр-хувийн хэвшлийн газрын мэргэжилтэн

Нэг цэгийн үйлчилгээний (НЦҮ) бэлтгэл ажил

ГХОЗБГ нь ГШХО-ын хууль тогтоомж, зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааг улам хялбарчлах үүднээс НЦҮ-г нэвтрүүлэхээр бэлтгэл ажлууд эхлээд байна.

ГХОЗБГ-ын хөрөнгө оруулагчийг дэмжих төв буюу одоогоор НЦҮ гэж нэрлэж байгаа үйлчилгээний гол зорилго нь гадаадын хөрөнгө оруулагчдад ГШХО-той холбоотой хууль тогтоомж, журам, зөвшөөрөл зэрэгтэй холбоотой асуудлаар бүх төрлийн үйлчилгээ, зөвлөгөөг үзүүлэх юм. Түүнчлэн ГШХО-ын талаар зөвлөгөө авсны дараа хөрөнгө оруулагч ХО шийдвэр гаргасан тохиолдолд хэрвээ хүсвэл ГХОЗБГ-ын мэргэжилтэн бусад төрийн байгууллагуудаас авах холбогдох тусгай зөвшөөрөл болон үүнтэй

холбоотой үйл ажиллагааг зуучлан хийж үзүүлэх боломжыг мөн НЦҮ-нд оруулж байгаа. Одоогийн байдлаар хөрөнгө оруулагч тусгай зөвшөөрөл авах гэх мэтэд өөр өөр агентлагууд руу заавал очиж үйлчлүүлэх шаардлагатай болдог.

Хуучин ГХОГ нь анх ГШХО-той холбоотой НЦҮ-ний талаар 1999 оноос төлөвлөж эхэлсэн бөгөөд 2000 онд энэ асуудлыг хариуцаж байсан хуучин Худалдаа үйлдвэрийн яам татан буугдаж Гадаад хэргийн яам болж өөрчлөгдсөнөөр энэ ажил зогссон. Харин сүүлийн жилүүдэд НЦҮ -ний хэрэгцээ шаардлага их байгаа учраас энэ ажил амжилттай хэрэгжсэнээр ГХО-ын үйлчилгээ тодорхой хэмжээгээр хялбар болох юм.

Гадаадын маш олон хөрөнгө оруулагчид

Хятад улсыг сонгодог нь ("China Plus One") гэж нэрлэсэн эрсдлийн олон хувилбарт стратегитай холбоотой. Харин сүүлийн үед Хятадын хөрөнгө оруулалтын орчин нь хөрөнгө оруулагчдад тийм ч таатай байгаа болж байгаа нь хөдөлмөрийн өртөг нэмэгдэж ажил хаялт ихсэж байгаа гэх мэт олон шалтгаантай. Харин хөрөнгө оруулагчдад таатай орчин бүрдүүлснээр Монгол улс хөрөнгө оруулагчдын сонирхолыг татаж эхэлж байгаа бөгөөд ГХОЗБГ ч энэ тал дээр онцгой анхаарал тавьж НЦҮ хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хара Хиромичи, PRFDI төслийн мэргэжилтэн, Байгууллагын үнэлгээ, Мэдээллийн менежмент (2)

Мэргэжилтнүүдийн судалгаа болон семинар

Өнгөрсөн жил хуучин ГХОГ дээр "Монголд хөрөнгө оруулалтыг татах санал зөвлөмж" сэдвээр семинарыг амжилттай зохион байгуулсан богино хугацааны мэргэжилтэн Хироши Үэно-г 2012 оны 9 сард дахин урьсан. Энэ удаа "ГШХО-ыг дэмжих бодлого болон Төр хувийн хэвшлийн түншлэл." сэдвээр лекц уншсан. Семинарт дотоодын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэхийн тулд ГШХО-ыг дэмжих, ялангуяа ЖДҮ, ХАА газар тариалангийн салбар болон уул уурхайг дэмжих асуудлуудыг онцолсон.

Профессор Үэно семинарын өмнө Өмнөговь аймагт судалгаа хийхээр 7 хоног явж Оюутолгой, Тавантолгой гэх мэт уул

дотоодын компани болон ЖДҮ-ийг хэрхэн хөгжүүлж болох талаар орон нутгийн холбогдох албаны хүмүүс болон уул уурхайн томоохон кампанитай уулзаж санал



Зураг 2: Таван Толгой уурхай

Өмнөговь аймагт хийсэн ярилцлагад тулгуурлан уул уурхайн салбараас орж ирж байгаа мөнгийг ХАА, газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд хэрхэн зориулж болох талаар санал зөвлөмж гаргасан. Үүнд: газар тариаланд ногоон хүлэмж болон усалгааны систем байгуулж өгөх гэм мэт. Семинарын 2-р хэсэгт төр хувийн хэвшлийн схем болон төрлүүдийн талаар орсон. Харин сүүлийн хэсэгт ГШХО-ыг дэмжих талаар ГХОЗБГ-с хийх боломжтой хувилбаруудыг танилцуулсан. Үүнд: 5 гол зарчим хөндсөн: (1) ашиг, (2) эрсдэл, (3) хуулийн зохицуулалт, (4) боломж (5) тусгай урамшуулал.

солилцсон.

Уг судалгаанд үндэслэн 2012 оны 10 сарын 2-4 өдрүүдэд семинар зохион байгуулсан. Семинар (1) ХАА, газар тариалан болон ЖДҮ-ийн салбарт ГШХО-ыг дэмжих бодлого болон үүнтэй холбоотой ярилцлагын үр дүн, (2) Дэд бүтэц болон Төр хувийн хэвшлийн түншлэл, (3) Хөрөнгө оруулалтыг дэмжих үйлчилгээ гэсэн үндсэн 3 хэсэгтэй явагдсан.

Семинарын хүрээнд Профессор Үэно ГШХО-ыг дэмжих бодлогын үндсэн асуудлууд, төр хувийн хэвшил, НЦҮ-ний үүрэг зэрэг асуудлуудыг жишээ саналд тулгуурлан авч үзсэн. Семинарын эхний хэсэг ГХОЗБГ хуучин ГХОГ-ын НЦҮ-ний үндсэн үүргийн талаар авч хэлэлцсэн. Мөн



Зураг 3: ГХОЗБГ семинар

Семинарт хамрагдсан ГХОЗБГ-ын 10 гаруй мэргэжилтэний ихэнх нь семинарыг бодит жишээнд тулгуурласан ойлгоход хялбар байсан гэж дүгнэсэн.

Риз Тажима, PRFDI төслийн зохицуулагч, ХО-ыг дэмжих үйлчилгээ (2)



Зураг 1: Эрдэнэс ТТ ярилцлага

уурхайн томоохон компаниудтай уулзсан. Уг аялалын гол зорилго нь уул уурхайн компаниудын ажилтай бодит байдал дээр танилцаж дүгнэлт, зөвлөмж гаргах явдал байсан. Тэр ГШХО-той холбоотойгоор